



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

007 2004 10 сарын 28 өдөр

Дугаар А/97

Төгөл

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.20 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд үйл ажиллагаа эрхэлж буй Аж ахуйн нэгжүүдэд хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: П. Мэндбаяр (ХЖДҮХ хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Г. Бямбахишиг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ц. Пүрэвсүрэн (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Б. Баярмаа (Мал эмнэлгийн Улсын байцаагч)

Н. Намхайбаатар (Мал аж ахуйн үйлдвэрийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э. Даваадорж (Хэсгийн цагдаа)

Нарийн бичгийн дарга: Д. Амаржаргал (Татварын Улсын байцаагч)

2. Хяналт шалгалт хийх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдамжийн дагуу хяналт шалгалтыг үр дүнтэй чанартай зохион байгуулж тайланг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (М. Батцогт)-д үүрэг болгос

ДАРГА  Н. БАТБАЯР



/Zahiramj/

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Н. БАТБАЯР

9072284 6715114494

Улаан-Уул

2024.10.28

**ХҮНСНИЙ ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ  
ИРГЭН, БАЙГУУЛЛАГА, ААН-Д ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ**

**Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл**

Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний ажлын чиг үүрэгт заагдсан хүнсний аюулгүй байдлыг хангуулахад хяналт тавих иргэн аж ахуй нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах зорилгын хүрээнд "Хүнсний аюулгүй байдлын тухай", "Хүнсний тухай хууль" "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль", "Тамхины хяналтын тухай хууль", болон бусад стандартын шаардлагыг үндэслэн хүнсний худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа албан байгууллага, иргэн ААН-ийн хүнсний бүтээгдэхүүний чанар стандарт, ариун цэврийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан шийдвэрлүүлэхэд шалгалтын зорилго оршино.

**Хоёр. Холбогдох хууль**

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих туай/Шинэчилсэн найруулга, Хоршооны тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Хүнсний тухай/ шинэчилсэн найруулга/ эдгээр хууль болон бусад холбогдох хууль тэдгээрийг даган гарсан журмууд болно.

**Гурав. Шалгалтын арга**

Чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд хэрэглэгчдэд хүрч хүний амь нас эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх, эрсдэлийг урьдчилан тогтоох, зөрчил дутагдлыг таслан зогсоох, шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг зориулалтын дагуу устгах арга хэмжээ авч, сургалт сурталчилгаа зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хэлбэрээр хийж гүйцэтгэнэ.

- Бүтээгдэхүүний хадгалах хугацаанд хяналт тавих,
- Бүтээгдэхүүний хадгалах нөхцөл /хөргөгч, хөлдөөгч, зоорь, агуулах гэх мэт/
- Заал танхим, өрөө тасалгааны эрүүл ахуй
- Тохирлын гэрчилгээний хугацаа
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа
- НӨАТ олгодог эсэх /пост машин/
- Хяналтын камер байрлуулсан эсэх

**Дөрөв. Хамрах хүрээ**

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол

үйлдвэр үйлчилгээ эрхлэгч иргэн, ААН, байгууллага хуулийн этгээдийг хамруулна.

**Тав . Ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

1. П. Мэндбаяр (Хүнс, ЖДҮ, Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
2. Б. Баярмаа (Мал эмнэлгийн Улсын байцаагч)
3. Г. Бямбахишиг(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
4. Э. Даваадорж (Хэсгийн цагдаа)
5. Н. Намхайбаатар (Мал аж ахуйн үйлдвэрийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
6. Ц. Пүрэвсүрэн (Хууль зүйн мэргэжилтэн)
7. Д. Амаржаргал (Татварын Улсын байцаагч)

**Зургаа. Хяналтын багийн бүрэн эрх**

Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын бараа бүтээгдэхүүн түүхий эд хяналт шалгалт хийх, агуулах зооринд хадгалагдаж байгаа бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийн чанар аюулгүй байдалтай танилцах.

Ямар нэгэн байдлаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах. Холбогдох этгээдэд мэдэгдэх

Хяналт шалгалт явцад худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч ААН, байгууллагын удирдлага албан хаагчаас санал хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авч хамтран ажиллах.

**Долоо. Авах арга хэмжээ**

Хүнс, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаар заавар зөвлөмж өгөх, чанарын шаардлага хангаагүй, хугацаа дууссан бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглох устгалд оруулах хүртэл арга хэмжээ авна.

**Найм. Хяналт шалгалт хийх хугацаа**

Хяналт шалгалтыг 2024 оны 11 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

**Ес. Шалгалтын дүнг танилцуулах.**

Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргад 11 дүгээр сарын 05-ний дотор танилцуулна.

**УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:**

Хүнс, ЖДҮ, Хоршооны  
асуудал хариуцсан  
мэргэжилтэн  
( Албан тушаал )

.....  
/П. Мэндбаяр /  
( Нэр, гарын үсэг )

2024.10.28

( Огноо )